



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.13 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 15¹.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг дүүргийн Засаг дарга нарт шилжүүлсэнтэй холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, худалдаа, үйлчилгээтэй холбоотой асуудлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/52 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

112320051-

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 11/29 дугаар
захирамжийн хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, МАГАДЛАН ШАЛГАХ ДҮГНЭЛТ ГАРГАХ
ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Дүүргийн менежер
Дэд дарга:	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүн:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Дүүргийн Татварын хэлтсийн дарга Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч 1 дүгээр хорооны Засаг дарга 2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичиг:	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн